

Нэгдүгээр хэсэг.

1. “Нийгмийн бүтэц гэдэг нь нийгмийн хэсэг, элементүүдийн хооронд бэхжсэн тогтвортой харилцаа холбоо” гэж үзсэн социологич хэн бэ? /2оноо/

- a. О.Конт b. Ж.Г.Мид c. В.Занден d. К.Маркс e. М.Вебер

2. Угсаатны хоёр дахь нэгж бөгөөд нийтлэг аялга, зан заншил, сэтгэлзүй, аж ахуй, нутаг дэвсгэр бүхий овгуудын нэгдэл Энэ нь..... /2оноо/

- a. Аймаг b. Ястан c. Угсаатан d. Үндэстэн e. Овог

3. Хүн бүр хаана, хэн болон төрж, хэрхэн амьдарч байгаагаас үл хамаарч хүмүүн болохынхоо хувьд адилхан үнэ цэнэтэй, эрх тэгш байх тухай ойлголтыг эрх зүйн шинжлэх ухаанд хэрхэн нэрлэдэг вэ? /2оноо/

- a. Хүний эрх b. Хүний эрхэм чана c. Тэгш байдал d. Тэгш эрх e. Хүний үнэ цэн, нэр төр

4. ДНБ-ийг тодорхойлохдоо илүүц зүйл дурдсан бол аль нь вэ? /2оноо/

- a. Эцсийн бараа үйлчилгээний зах зээлийн үнийн дүн
b. Тухайн улсын хэмжээгээр буюу газар нутаг дээр үйлдвэрлэсэн байх
c. Нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн байх
d. Тухайн жилд үйлдвэрлэсэн боловч борлогдож амжаагүй бүтээгдэхүүний үнэ
e. Эдийн засгийн салбар дах хууль бус үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг оруулж тооцохгүй байх

5. Дараах ойлголтуудаас аль нь хүний эрхийн зарчимд үл хамаарах вэ? /2оноо/

- a. Тэгш байх. b. Ардчилсан байх c. Үүрэг хариуцлага хүлээх d. Түгээмэл байх
e. Ялгаварлан гадуурхахгүй байх

6. Одоо мөрдөгдөж байгаа Үндсэн хууль хэдэн бүлэг, хэдэн зүйлтэй вэ? /2оноо/

- A. 6 бүлэг 70 зүйлтэй b. 8 бүлэг 49 зүйлтэй c. 4 бүлэг 69 зүйлтэй
d. 7 бүлэг 60 зүйлтэй e. 12 бүлэг 282 зүйлтэй

7. Олон улсын харилцаанд улс орныг албан ёсны гэхдээ бүрэн бус хүлээн зөвшөөрснийг гэж нэрлэдэг. /2оноо/

- a. Статус кво b. Де-факто c. Автономит d. Де-юре e. Транзит

8. “Мөнхийн дайсан гэж байхгүй, мөнхийн хөрш байдаг” гэж хэн хэлсэн бэ? /2оноо/

- a. А.Линколи. b. М.Вебер c. К.Маркс d. У.Черчилль e. Ш.Монтескье

9. Нийгэм, нийгмийн бүлгийн олонх гишүүдийн хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, хүлээлттэй үл нийцэх төлвийг нийгмийн шинжлэх ухаанд хэрхэн нэрлэдэг вэ? /2оноо/

- a. Аялдах үйлдэл b. Нийгмийн хяналт c. Нийгмийн гажуудал d. Гэмт хэрэг e. Нийгмийн зан үйл

10. Бид аливаа үйл явдал, үзэл санааг дэмжих, буруутгах, шүүмжлэх, магтах зэргээр янз бүрээр үнэлж, дүгнэж байдаг. Тухайлбал нийгмийн бүлэг, хамт олон, бие хүний зан төлөв, үйлдлийг тодорхой шалгуурт нийцэж байна уу, үгүй юу гэдгийг шүүн тунгаах үйл явц. Энэ нь:..... /2оноо/

- a. Үнэлгээ b. Үнэт зүйл c. Үнэлэмж. d. Үнэлэмжийн баримжаа e. Үнэт чанар

11. Хөдөлмөрийн гэрээ гэсэн ойлголтонд аль бодомж нь хамаарах вэ? /2оноо/

- a. Хөдөлмөрийн гэрээ нь хугацаатай ба хугацаагүй байгуулагддаг
b. Хөдөлмөрийн гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээг бичгээр байгуулж, гэрээний нэг хувийг ажилтанд өгөх үүрэгтэй.
c. Хөдөлмөрийн гэрээ байгуулах үед талууд гэрээний гол нөхцлүүдийн аль нэгийг тохироогүй бол гэрээ байгуулсанд тооцохгүй
d. Хөдөлмөрийн хуульд зааснаар ажилтан өдөрт 8 цаг, долоо хоногт 40 цаг хүртэл ажиллана гэж заасан байдаг.
e. Дээрх бүгд хамаарна

12. Иргэд наслах, эмнэлгээр эмчлүүлэх, өвдөх, тахир дутуу болох, ажилгүй болох зэрэг тохиолдолд нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн туслалцааг авах, түүнийг дуусгавар болгохтой үүсч буй харилцааг эрх зүйн шинжлэх ухаанд хэрхэн нэрлэдэг вэ? /2оноо/

- a. Иргэн ба захиргаа хоорондын харилцаа
- b. Иргэний эрх зүйн харилцаа
- c. Хөдөлмөрийн эрх зүйн харилцаа
- e. Иргэдийн хоорондын харилцаа
- e. Нийгмийн хамгааллын эрх зүйн харилцаа

13. Өгөгдлийг зөв харгалзуулна уу? /2оноо/

- 1. Цэвэр экспорт a. Экспортын орлогоос импортын зардлыг хасах
- 2. Бодит ДНБ b. ДНБ-ийг нийт хүн амд харьцуулсан үзүүлэлт
- 3. Нэрлэсэн ДНБ c. Өнөөгийн үнээр тооцсон ДНБ
- 4. Нэг хүнд ногдох ДНБ d. Тогтмол үнээр тооцсон ДНБ
- a. 1d 2b 3c 4a b. 1c 2b 3d 4a c. 1a 2b 3c 4d
- d. 1b 2c 3a 4d e. 1a 2d 3c 4b

14. Нийгэм, эдийн засгийн үзэгдлийн динамик хандлагуудыг шинжих үзүүлэлтүүд -ийг зөв харгалзуулна уу? /2оноо/

- 1. Абсолют цэвэр өсөлт a. Тухайн оны түвшнээс өмнөх оны түвшинг хасаж тодорхойлно.
- 2. Өсөлтийн хурд b. Тухайн оны түвшинг өмнөх оны түвшинд харьцуулж тодорхойлно.
- 3. Цэвэр өсөлтийн хурд c. Тухайн оны түвшинг өмнөх оны түвшинд харьцуулж 100 хувиар үржүүлж 100 хувийг хасна.
- a. 1b 2a 3c b. 1c 2b 3a c. 1a 2b 3c d. 1b 2c 3a e. 1a 2c 3b

15. 1992 оны Монгол улсын Үндсэн хуульд зааснаар иргэний журамт үүрэгт хамааралгүй нь аль вэ? /2оноо/

- a. Сурч боловсрох b. Хөдөлмөрлөх c. Эрүүл мэндээ хамгаалах
- d. Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх e. Байгаль орчноо хамгаалах

16. Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын гаргадаг эрх зүйн акт аль нь вэ? /2оноо/

- a. Тушаал, дүрэм b. Хууль c. Тогтоол, захирамж. d. Зарлиг e. Шийдвэр, тушаал

17. Монгол улсын гадаад бодлогын нэг дэх чиглэл аль нь вэ? /2оноо/

- a. Хөрш орнуудтай найрсгаар, тэнцвэртэй харилцах
- b. Азийн бүс нутгийн улс төр, эдийн засгийн интеграцид оновчтой оролцох
- c. Өрнө, дорнын өндөр хөгжилтэй гүрнүүдтэй найрсаг харилцаа хөгжүүлэх
- d. Хөгжиж буй орнуудтай нийтлэг зорилтын хүрээнд хамтран ажиллах
- e. НҮБ болон төрөлжсөн байгууллагууд, дэлхийн банкттай хамтран ажиллах

18. “ХИҮ Далай лам, Билл Гейтс” зэрэг субъектүүд улс бус оролцогчдын аль ангилалд хамаарах вэ? /2оноо/

- a. Олон улсын байгууллага
- b. Нөлөө бүхий хүн
- c. Террорист, зэвсэгт бүлэглэлүүд
- d. Олон улсын төрийн бус байгууллага
- e. Шашны байгууллага

19. Өгөгдлийг зөв харгалзуулна уу? /2оноо/

1	Байр суурь	a	Тухайн байр суурь бүхий хүн юуг хийх нь зөвшөөрөгдөж байгааг илэрхийлнэ.
2	Үүрэг	b	Эзэлж буй байр сууриас үүдэн бий болж, заавал биелүүлэх ёстой, хэм хэмжээлэг шинжтэй зан үйлдлүүдийн цогц
3	Эрх	c	Хувь хүний эдлэх эрх, боломж, гүйцэтгэх үүрэг, бусдын зүгээс хандах хандлагын цогц

A. 1b 2c 3a b. 1c 2b 3a c. 1a 2c 3b d. 1b 2a 3c e. 1a 2b 3c

20. Эхчүүдийн орлогыг нэмэгдүүлэх зорилготой халамжийн бодлогонь тэдний хөдөлмөр эрхлэлтийн түвшинг бууруулан, бусдаас хамааралт байдлыг нэмэгдүүлдэг. Энэ нь: /2оноо/

- a. Ил чиг үүрэг b. Далд чиг үүрэг c. Сөрөг чиг үүрэг
- d. Тодорхой чиг үүрэг e. Тодорхой бус чиг үүрэг

21. Өдгөө хүмүүс 6000 гаруй хэлээр ярьж байгаа ч манай гарагийн хүнамын 90 орчим хувь нь өргөн тархсан.....хэлээр харилцаж байна. /2оноо/

- a. 20 b. 99. c. 87 d. 83 e. 68

22. Дараах бодомжуудад дүн шинжилгээ хийнэ үү? /Бурууг олно уу?/ /2оноо/

- a. Олон хэв загварын соёл нь нээлттэй байдаг.
 b. Нэг хэв загварын соёл нь нэг ерөнхий итгэл үнэмшил, үнэт зүйлстэй байна .
 c. Нэг хэв загварын соёл нь гадны соёлын элементүүд нэвтрэн шингэх боломж хомс
 d. Социализмын үед Монголд олон хэв загварын соёл байсан
 e. Алдаатай бодомж алга

23. Тодорхой ажиллагааг эхлүүлэх, эсвэл дуусгавар болгох тухай захиргааны байгууллагад гаргасан хүсэлтийг гэнэ. /2оноо/

- a. Мэдэгдэл b. Гомдол c. Нэхэмжлэл d. Өргөдөл e. Баримт

24. Эрх зүйн бүрэн бус чадамжтай хүн гэж хэнийг хэлэх вэ? /2оноо/

- a. 14-18 хүртэлх насны хүүхэд b. 18- аас дээш насны хүмүүс c. 7-14 хүртэлх насны хүүхэд
 d. 7 хүртэлх насны хүүхэд e. 16 хүртэлх насны хүүхэд

25. Тухайн улсын хэмжээнд жилийн турш үйлдвэрлэсэн баялгийг орлогыннийлбэр дүнгээр тодорхойлох аргыг гэнэ. /2оноо/

- A. ДНБ-ийг орлогоор тооцох b. ҮНБ-ийг зардлаар тооцох. c. ДНБ-ийг зардлаар тооцох d. ҮНБ-ийг орлогоор тооцох
 e. Нэрлэсэн ДНБ-ийг орлогоор тооцох

26. Ажилгүйдлийн хэлбэрүүдэд тохирох жишээг зөв харгалзуулна уу? /2оноо/

1	Бүтцийн ажилгүйдэл	a	Иргэдийн худалдан авалт муудаж олон үйлдвэрийн газар хаалгаа барьснаар Хуяг ажилгүй болсон
2	Мөчлөгийн ажилгүйдэл	b	Уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалт буурсантай холбоотой уурхай хаагдаж уурхайчид ажлаа алдсан
3	Улирлын ажилгүйдэл	c	Навчаа хүссэн ажлаа хийхийн тулд гадаад хэл сурахааражлаас завсардсан
4	Шилжилтийн ажилгүйдэл	d	Сугар барилга дээр ажилладаг ч өвлийн улиралд ажилнь түр хугацаагаар зогссон тул одоо ажилгүй байгаа

- a. 1d 2c 3b 4a b. 1a 2b 3c 4d c. 1b 2a 3d 4c d. 1c 2a 3d 4b e. 1b 2a 3c 4d

27. Цэгийн оронд тохирох ойлголтыг сонгоно уу? /2оноо/

Ард түмнээс олгосон эрх мэдлийн хүрээнд ажиллах төрийн хэлбэр, дээдэрх мэдлийг ард түмэнтэй хамтран эдлэх эрхийн тогтолцоог гэнэ.

- a. Эрх мэдэл b. Ардчилал c. Үндсэн хууль d. Гүйцэтгэх засаглал e. Төрийн үйлчилгээ

28. 1990 оны өмнөх Монгол төрийн бодлогын гол чиглэлд аль нь хамаарахгүй вэ? /2оноо/

- a. Би давуу эрхтэй гэх байдал b. Ардчилсан бус байдал c. Тоталитар дэглэм. d. Ганц намын тогтолцоо e. Дээрх бүгд хамаарна

29. Монголын гадаад бодлогын аль зарчмыг өөрөөр прагматик хэмээн нэрлэдэг вэ? /2оноо/

- a. Олон тулгуурт байх
 b. Тэнцвэртэй байх
 c. Үндэсний эрх ашигт нийцсэн байх
 d. Идэвхтэй байх
 e. Бие даасан байх

30. Олон улсын харилцаанд хууль ёсны гэх ба тухайн улсыг бүрэн зөвшөөрснийг гэж нэрлэдэг. /2оноо/

- A. Статус кво b. Де-факто c. Автономит d. Де-юре e. Транзит

ХОЁРДУГААР ХЭСЭГ:

31. Дараах өгөгдлийг зөв холбоно уу? /4 оноо/

1	Гэр бүл	a	Нийгмийн гишүүнийг төрүүлэх, нийгэмшүүлэх
---	---------	---	---

2	Боловсрол	b	Шинэ мэдлэг бүтээх, мэдлэгийг хойч үедээ уламжлуулах
3	Эдийн засаг	c	Амгалан тайван байдлыг хангах, нийтлэг асуудлыг шийдэх
4	Төр засаг	d	Хэрэгцээт бараа, үйлчилгээгээр хангах

1- 2- 3- 4-

32. Дараах өгөгдлийг зөв холбоно уу? /6 оноо/

1	Бэлгэдлийн чиг үүрэг	a	Соёл нь нийтлэг итгэл үнэмшил, үнэлэмжийн тогтолцоог бүрдүүлэх замаар нийгмийг нэгтгэдэг.
2	Үнэлэмж, хэм хэмжээний чиг үүрэг	b	Нийгэмд үйлчилж байдаг хэм хэмжээг эзэмшснээр хүмүүс амьдралын чиг баримжаагаа олж авдаг.
3	Нэгтгэн зохицуулах чиг үүрэг	c	Соёлын үзэгдлүүд тэмдгэн хэлбэрээр оршдог. Тэмдгийн хамгийн хэлбэр нь хэл юм.
4	Үнэлэмж	d	Нийт хүн төрөлхтөний хувьд хүлээн зөвшөөрөгддөг утгат чанарууд

1- 2- 3- 4-

33. Дараах өгөгдлийг зөв холбоно уу?

1	Төртэй хариуцлага тооцох	a	Төрийн бус байгууллага зэрэг нийгмийн бусад бүх хэсгүүд хүний эрхийг хамгаалах үүргийг хүлээнэ.
2	Хувь хүнтэй хариуцлага тооцох	b	Хүн бүр хүний эрхийг хүндэтгэх болон хүний эрхийг зөрчдөг байгууллага, хүмүүстэй тэмцэх үүрэгтэй.
3	Бусад этгээдтэй хариуцлага тооцох	c	Хүний эрхийг төр өөрийн үзэмжээр өгдөггүй бөгөөд хүндэтгэх, хамгаалах, хангахаас татгалзах ёсгүй
4.	Хуваагдашгүй байх	d	Иргэний, улс төрийн, нийгэм эдийн засаг, соёлын болон хамтын эрх зэрэг хүний бүх эрчүүд нэгдмэл, хуваагдашгүй байдаг.

1- 2- 3- 4-

34. Өгөгдлийг зөв харгалзуулна уу?

1	Иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл	a	Ажилтан сахилгын зөрчлийг давтан гаргасан, эсвэл 60 нас хүрч тэтгэвэр авах эрх үүссэн бол
2	Гэрээ байгуулах үндэслэл	b	Хуульд заасан талууд тохиролцсон нэг баримт үйлдэж, гарын үсэг зурах буюу саналыг зөвшөөрснөө илэрхийлэх
3	Хөдөлмөрийн гэрээ цуцлах үндэслэл	c	Оюуны үнэт зүйл бүтээх, үндэслэлгүйгээр эд юмс олж авах, эзэмших
4.	Иргэний эрх зүйн бүрдэл	d	Субъект, объект, агуулга

1- 2- 3- 4-

35. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу? /4 оноо/

1	Бүтцийн ажилгүйдэл	a	Иргэдийн худалдан авалт муудаж олон үйлдвэрийн газар хаалгаа барьснаар Хуяг ажилгүй болсон
2	Мөчлөгийн ажилгүйдэл	b	Уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалт буурсантай холбоотой уурхай хаагдаж уурхайчид ажлаа алдсан

3	Улирлын ажилгүйдэл	c	Навчаа хүссэн ажлаа хийхийн тулд гадаад хэл сурахаар ажлаас завсардсан
4	Шилжилтийн ажилгүйдэл	d	Сугар барилга дээр ажилладаг ч өвлийн улиралд ажилнь түр хугацаагаар зогссон тул одоо ажилгүй байгаа

1- 2- 3- 4-

36. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу? /4оноо/

1	Өрх гэрийн хэрэглээний зардал	a	ААН-үүдийн хөрөнгө оруулалт болох барилга барих, тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө худалдан авахад гаргасан зардал
2	Аж ахуйн нэгжийн зардал	b	Төрөөс төрийн албан хаагчдад зориулан бараа, үйлчилгээ худалдан авах, сургууль, эмнэлэг, зам зэргийг барихад гаргасан зардал
3	Төрийн зардал	c	Гадаадын иргэдээс бараа, үйлчилгээг худалдан авахад зарцуулсан зардал
4	Гадаад хэрэглэгчийн зардал	d	Өрх гэрүүд хэрэглээндээ зориулан хүнс, бараа болон үйлчилгээ худалдан авахад зарцуулсан зардал

1- 2- 3- 4-

37. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

1	Хүний эрх, эрх чөлөө	a	Олон ургалч үзлийг хөгжүүлэх бөгөөд сонгогчдод олоннам, нэр дэвшигчдийн улс төрийн хувилбараас өөрт ашигтай сонгох боломж
2	Тэгш эрх	b	Ардчилсан нийгэмд хаан, ерөнхийлөгч, сайд хэн ч хуулиас дээгүүр эрх эдлэхгүй, иргэн бүр хуулийг сахиж, түүнийг зөрчвөл хариуцлага хүлээнэ.
3	Олон намын тогтолцоо	c	Нийгмийн харилцаанд оролцох боломжийг илэрхийлсэн ойлголт бөгөөд хүндэтгэн үзэхийг чухалчилдаг.
4	Хуулийн засаглал	d	Арьс өнгө, шашин шүтлэг, угсаа хүйс, үзэл бодлоор ялгаварлахгүй байхыг хэлнэ

1- 2- 3- 4-

38. Монгол улсын эрх мэдлийн хуваарилалтыг зөв харгалзуулна уу?

1	Хууль тогтоох эрх мэдэл	a	Улсы дээд шүүх, Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокурор
2	Гүйцэтгэх эрх мэдэл	b	Улсын Их Хурал
3	Шүүх эрх мэдэл	c	Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар
4	Засгийн газар	d	Сайд, Яам, Хэрэгжүүлэгч агентлаг, Орон нутгийн агентлаг

1- 2- 3- 4-

39. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу? /4оноо/

1	Олон улсын харилцаанд оролцох үүрэг	a	Монгол улс бусад улсын улс төр, эдийн засаг, соёлын хүч чадавхи, үйл ажиллагааг өөрийн боломжоор хянах, үнэлэх явдал юм.
2	Олон улсын харилцаанд оролцох үйл ажиллагааг чиглэл	b	Олон улсын харилцаанд улс төр, эрх зүй, эдийн засаг, харилцаа, худалдаа, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн гэсэн үйл ажиллагааны чиглэлээр хамтран ажилладаг.

3	Олон улсын харилцаанд оролцох нөлөө	c	Олон улсын улс төр, эрх зүй, эдийн засаг, соёлын зэрэг олон талт харилцаанд гадаад бодлогоороо дамжуулан оролцох үйл ажиллагааны цар хүрээ, ач холбогдол
4	Олон улсын харилцаанд оролцогчдын түвшин	d	Үндэсний, бүс нутгийн, дэлхийн

1- 2- 3- 4-

40. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

1	НҮБ	a	Ерөнхий Ассамблей, Аюулгүйн зөвлөл, Эдийн засагнийгмийн зөвлөл, Олон улсын шүүх
2	НҮБ-ын зорилго	b	Олон улсын засгийн газар хоорондын хамтын түгээмэл, нээлттэй, улс орнуудын харилцаа, хамтын ажиллагааны хамгийн олон салбар чиглэлийг хамардаг байгууллага
3	НҮБ-ын гол байгууллага	c	Франц, АНУ, БНХАУ, ОХУ, Англи
4	НҮБ-ын хориг тавих боломжтой улсууд	d	Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх явдлыг үндсэн зорилго болгодог

1- 2- 3- 4-

10 ДУГААР АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР
ХУВИЛБАР Б

ШИФР:
ХУГАЦАА 80 МИН

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. “Бүтэц - чиг үүргийн онол”-ын хандлагын гол төлөөлөгч аль нь биш вэ? /2 оноо/
a. О.Конт b. К.Маркс c. Э.Дюркгейм d. Т.Парсонс e. Р.Мертон
2. Хүн амын болон соёлын нөхөн үйлдвэрлэлээрээ өөрийн залгамж, тогтвортой чанарыг хангадаг, нэг нутаг дэвсгэр дээр амьдардаг, өөрийн зохион байгуулалт, эмх цэгц бүхий, улс төрийн хувьд биеэ даасан өөрсдийгөө тухайн нийгэмд харьяалуулдаг хүмүүсийн тогтвортой нэгдлийг юу гэдэг вэ? /2 оноо/
a. Бүлэг b. Нийгэм c. Үндэстэн d. Гэр бүл e. Нийтлэг
3. Тодорхой ажиллагааг эхлүүлэх, эсвэл дуусгавар болгох тухай захиргааны байгууллагад гаргасан хүсэлтийг гэнэ. /2 оноо/
a. Мэдэгдэл b. Гомдол c. Нэхэмжлэл d. Өргөдөл e. Баримт
4. Тодорхой хэмжээний мөнгийг тогтоосон хугацааны дараа, зохиххүүтэйгээр эргүүлэн төлөхөө амлаж байгааг баталсан үнэт цаасыг.....гэнэ. /2 оноо/
a. Хувьцаа b. Эрхийн бичиг c. Мөнгө d. Бонд e. Санхүүгийн зах зээл
5. Цэгийн оронд тохирох ойлголтыг сонгоно уу? /2 оноо/
Ард түмнээс олгосон эрх мэдлийн хүрээнд ажиллах төрийн хэлбэр, дээдэрх мэдлийг ард түмэнтэй хамтран эдлэх эрхийн тогтолцоог гэнэ.
a. Эрх мэдэл b. Ардчилал c. Үндсэн хууль d. Гүйцэтгэх засаглал e. Төрийн үйлчилгээ
6. 1990 оны дараах ардчилсан Монгол төрийн бодлогын гол чиглэлд аль нь хамаарахгүй вэ? /2 оноо/
a. Олон намын тогтолцоо b. Ардчилсан ил тод байдал c. Хүний эрх, эрх чөлөө
d. Хүмүүнлэг, ардчилсан нийгэм e. Дээрх бүгд хамаарна
7. Дэлхийн улс ба улс бус оролцогчид хоорондын олон талт харилцаа, тэдний гадаад бодлого, үйл ажиллагааг судалдаг нийгмийн шинжлэх ухааны салбарыг хэрхэн нэрлэдэг вэ? /2 оноо/
A. Дипломат харилцаа b. Гадаад харилцаа c. Олон талт харилцаа
d. Олон улсын харилцаа e. Дипломат бус харилцаа
8. Олон улсын харилцааны “ улс” оролцогчдын ангилалд аль нь хамаарахгүй вэ? /2 оноо/
a. Их гүрэн b. Дунд улс c. Бага улс d. Хөгжингүй улс e. Дээрх бүгд хамаарна
9. Нийгэмшилтийн гол агентад аль нь хамаарахгүй вэ? /2 оноо/
a. Гэр бүл b. Сургууль c. Үе тэнгийнхэн d. Хэвлэл мэдээлэл e. Сүм хийд
10. гэдэг нь”cultura” латин хэлний”соёолуулан боловсруулах, хөрс боловсруулах” гэсэн утгыг илтгэдэг. /2 оноо/
a. Соёл b. Дэд соёл c. Нийтийн соёл d. Ардын соёл e. Урлаг
11. 10 хүртэлх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулсан эцэг, эх, асран хамгаалагч нарт ямар төрлийн шийтгэл ногдуулах вэ? /2 оноо/
A. Тусгайлан олгосон эрхийг хасах B. Хууль бус орлого, эд зүйлийг хураах.
C. Торгох d. Баривчлах e. Сануулга өгөх
12. Иргэд наслах, эмнэлгээр эмчлүүлэх, өвдөх, тахир дутуу болох, ажилгүй болох зэрэг тохиолдолд нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн туслалцааг авах, түүнийг дуусгавар болгохтой үүсч буй харилцааг эрх зүйн шинжлэх ухаанд хэрхэн нэрлэдэг вэ? /2 оноо/
a. Иргэн ба захиргаа хоорондын харилцаа b. Иргэний эрх зүйн харилцаа c. Хөдөлмөрийн эрх зүйн харилцаа
e. Иргэдийн хоорондын харилцаа e. Нийгмийн хамгааллын эрх зүйн харилцаа
13. Цэгийн оронд тохирох хариултыг олно уу? Амралт, аялал жуулчлал, газар тариалангийн үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудад өвөл ажилгүйдэл нэмэгддэг. Ингэж үүссэн ажилгүйдлийн....гэнэ. /2 оноо/
A. Бүтцийн ажилгүйдэл b. Циклийн ажилгүйдэл c. Улирлын ажилгүйдэл
d. Зөрөөний ажилгүйдэл e. Шилжилтийн ажилгүйдэл

14. Эдийн засагт бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ ерөнхийдөө өсөж хүн амын худалдан авах чадвар буурах үзэгдлийг юу гэж нэрлэх вэ? /2 оноо/

а. Хэрэглээний үнийн индекс b. Дефля c. Хэрэглээний сагс d. Инфляци e. Хэрэглээний бараа үйлчилгээний жин

15. “Улс төр бол нийгэм дэх үнэт зүйлсийг эрх мэдэлд тулгуурлан хуваарилан байршуулах үйл байдал” гэж тодорхойлсон эрдэмтэн хэн бэ? /2 оноо/

A. X. Лассуэл b. И. Макиавелли c. Д. Истон d. М. Вебер e. Аристотель

16. Баг, хорооны нутгийн өөрөө удирдах байгууллагыг хэрхэн нэрлэдэг. /2 оноо/

а. Тохируулагч агентлаг b. Хэрэгжүүлэгч агентлаг c. Яам d. Иргэдийн төлөөлөгчдийн хурал
e. Иргэдийн нийтийн хурал

17. Монгол Улсын гадаад бодлогын хэд хэдэн зарчмууд бий. “Гадаад харилцаа, хамтын ажиллагаандаа нөөц бололцоог аль болох бүрэн дайчлан зохион байгуулах шаардлага нь” аль зарчимд хамаарах вэ? /2 оноо/

а. Тэнцвэртэй байх b. Идэвхтэй байх
c. Үндэсний эрх ашигт нийцсэн байх d. Олон тулгуурт байх. e. Прагматик байх

18. Монгол Улсын хоёр хөрштэйгээ харилцах чиглэлд аль нь хамаарахгүй. /2 оноо/

A. Эдийн засгийн болон улс төрийн чиглэл
B. Соёлын болон боловсролын чиглэл
C. Хүмүүнлэгийн болон шинжлэх ухааны чиглэл
D. Хөршийн болон хамтын ажиллагааны чиглэл
E. Дээрх бүгд хамаарна

19. Судалгаанд оролцогчдын дунд амьдарч, ажиллах замаар мэдээлэл цуглуулах нь: /2 оноо/

а. Хөндлөнгийн ажиглалт b. Дотроос нь ажиглах
c. Далд ажиглалт d. Ил ажиглалт e. Оролцон ажиглах

20. Нийгмийн институтын үүргийг зөв харгалзуулна уу? /2 оноо/

1	Гэр бүл	a	Эрүүл аж төрөх, эрүүл мэндийг хангах хамгаалах
2	Боловсрол	b	Нийгмийн нэгдэл нягтралыг хангах, дээд ариун зүйд дитгэх, сүсэглэх
3	Эдийн засаг	c	Амгалан тайван байдлыг хангах, нийтлэг асуудлыг шийдэх
4	Төр засаг	d	Хэрэгцээт бараа, үйлчилгээгээр хангах
5	Шашин	e	Шинэ мэдлэг бүтээх, мэдлэгийг хойч үедээ уламжлуулах
6	Эрүүл мэнд, спорт	f	Нийгмийн гишүүнийг төрүүлэх, нийгэмшүүлэх

а. 1d 2e 3c 4a 5b 6f b. 1f 2e 3d 4c 5b 6a c. 1a 2b 3c 4d 5e 6f
d. 1e 2f 3d 4a 5b 6c e. 1b 2a 3f 4e 5d 6c

21. Өгөгдлийг зөв харгалзуулна уу? /2 оноо/

1	Домог	a	Өөрийн нэр томъёо, багаж хэрэгсэл, туршилтын тоноглол зэргийг ашигладаг. Энэ зорилгын дагуу эрдэм судалгааны байгууллагууд ажилладаг.
2	Шашин	b	Хүн төрөлхтний язгуур сэтгэлгээ бөгөөд эртний нийгэмд хамаарна. Ёс жаяг, зан үйл хэвшиж тогтсоноор хорио цээрийн хэм хэмжээ, бэлгэдлийн эх үндэс тавигдсан.
3	Шинжлэх ухаан	c	Энэ байгууллагын хамгийн том хэлбэр нь сүм хийд бөгөөд археологийн судалгаагаар сүсэг бишрэлийн энгийн хэлбэрүүдийг 40 мянган жил оршин тогтносон гэж судлаачид тэмдэглэдэг.

а. 1b 2c 3a b. 1a 2c 3b c. 1c 2b 3a d. 1c 2a 3b e. 1b 2a 3c

22. Үнэлэмжүүдийн өгөгдлийг зөв харгалзуулна уу? /2 оноо/

1	Ёс суртахууны үнэлэмж	a	сайхан, муухай
2	Шашны үнэлэмж	b	буян, нүгэл
3	Гоо сайхны үнэлэмж	c	сайн, муу
4	Шинжлэх ухааны үнэлэмж	d	үнэн, худал

a. 1d 2c 3a 4b b. 1a 2d 3b 4c c. 1c 2b 3a 4d d. 1c 2a 3d 4b e. 1b 2a 3c 4d

23. Иргэний эрх зүйн харилцаа нь субъект, объект, агуулга гэсэн бүрдэлхэсгүүдтэй .Дараах өгөгдлөөс аль нь иргэний эрх зүйн харилцааны агуулгад хамаарах вэ? /2 оноо/

- a. Иргэд хоорондын харилцаанд оролцож, хуулиар олгогдсон эрх эдэлж, үүрэг хүлээж буй этгээд
- b. Эрх зүйн чадвар, чадамжтай этгээд
- c. Эдийн баялаг болох эд юмс, эдийн бус баялаг болох оюуны үнэтзүйлс
- d. Талууд тэгш эрхийн үндсэн дээр бий болсон тэдний эрх үүрэг
- e. Үйлдлээр эрх олж авах, үүрэг бий болгох эрх зүйн үр дагавар

24. Өгөгдлийг зөв харгалзуулна уу? /2 оноо/

1	Иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл	a	Ажилтан мэргэжил, ур чадвар, эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй бол
2	Гэрээ байгуулах үндэслэл	b	Саналыг хариу илгээх хугацаатайгаар илгээсэн бөгөөд дурдсан хугацаанд нөгөө талаас зөвшөөрсөн хариу авсан бол
3	Хөдөлмөрийн гэрээ цуцлах үндэслэл	c	Агуулгын хувьд хуульд үл харшлах хэлцэл, гэмхор учруулах

a. 1c 2b 3a b. 1a 2c 3b c. 1a 2b 3c d. 1b 2a 3c e. 1b 2c 3a

25. Зөв холбоно уу? /2 оноо/

- 1. Шилжилтийн ажилгүйдэл a. Эдийн засгийн уналтын үед бий болдог
- 2. Бүтцийн ажилгүйдэл b. Цаг улирлын байдалтай холбоотой
- 3. Мөчлөгийн ажилгүйдэл c. Шинэ салбар мэргэжлийн шаардлага
- 4. Улирлын ажилгүйдэл d. Нэг ажлаас нөгөө ажилд шилжих

a. 1d 2b 3c 4a b. 1c 2b 3d 4a c. 1d 2c 3a 4b
d. 1b 2c 3a 4d e. 1a 2d 3c 4b

26. Утгаар нь зөв тохируулна уу? /2 оноо/

- 1. Гипер инфляци a. Инфляцийн хурд 54.2 %
 - 2. Цогио инфляци b. Инфляцийн хурд 123.7 %
 - 3. Мөлхөө инфляци c. Инфляцийн хурд 4.7 %
- a. 1b 2c 3a b. 1b 2a 3c c. 1a 2b 3c d. 1c 2a 3b e. 1c 2b 3a

27. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу? /2 оноо/

1	Иргэдийн улс төрийн оролцоо	a	Ардчилсан нийгэм нь иргэдийг боловсролтой болоход анхаардаг бөгөөд боловсролтой иргэд нь ардчиллыг хөгжүүлэх гол хөшүүрэг
2	Нийтэд тайлагнах, ил тод байх ёс	b	Ардчилсан нийгэм нь иргэдийн эрхийг хамгаалах, албан тушаалтан хаагчдын эрх мэдлээ урвуулан, хэтрүүлэх явдлаас сэргийлэх
3	Эрх мэдлээ хэтрүүлэхэд хяналт тавих	c	Ардчилсан нийгэмд сонгогдсон болон томилогдсон албан тушаалтан ард олонд тайлангаа тавих үүрэгтэй. Тэд өөрсдийн үйл ажиллагааны төлөө хариуцлага хүлээнэ.

4	Тэгш эрх	d	Арьс өнгө, шашин шүтлэг, угсаа, хүйс, үзэл бодлоор ялгаварлахгүй байхыг хэлнэ.
5	Боловсрол	e	Сонгуульд саналаа өгөх, нэрээ биелүүлэх, жагсаал цуглаан хийх, төрийн байгууллага, албан тушаалтанд санал хүсэлт гаргах зэрэг олон хэлбэрээр хэрэгжинэ.

A. 1e 2b 3c 4a 5d B. 1d 2a 3b 4c 5e C. 1e 2c 3b 4d 5a D. 1a 2c 3b 4d 4eE. 1c 2b 3e 4b 5a

28. 1992 оны шинэ Үндсэн хуулинд Монгол улсын Засгийн газрын тухайзаасан байдаг. Доорх өгөгдөлүүдээс аль нь алдаатай вэ? /2 оноо/

A. Монгол Улсын Засгийн газар нь Ерөнхий сайд, гишүүдээс бүрддэг хамтын удирдлагын байгууллага юм.

B. Ерөнхий сайдыг Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр УИХ-аас томилох ба Засгийн газрын бусад гишүүдийг Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр УИХ томилдог

C. Засгийн газрын үйл ажиллагааны эрх зүйн хэлбэр нь түүний тогтоол, захирамж юм.

D. Засгийн газрыг Ерөнхий сайд удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг УИХ-ын өмнө хариуцах ба гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төрийн байгууллага

29. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу? /2 оноо/

1	Олон улсын харилцаанд оролцох үүрэг	a	Монгол улс бусад улсын улс төр, эдийн засаг, соёлын хүч чадавхи, үйл ажиллагааг өөрийн боломжоор хянах, үнэлэх явдал юм.
2	Олон улсын харилцаанд оролцох үйл ажиллагааг чиглэл	b	Олон улсын харилцаанд улс төр, эрх зүй, эдийн засаг, харилцаа, худалдаа, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн гэсэн үйл ажиллагааны чиглэлээр хамтран ажилладаг.
3	Олон улсын харилцаанд оролцох нөлөө	c	Олон улсын улс төр, эрх зүй, эдийн засаг, соёлын зэрэг олон талт харилцаанд гадаад бодлогоороо дамжуулан оролцох үйл ажиллагааны цар хүрээ, ач холбогдол

A. 1b 2c 3a b. 1a 2c 3b c. 1c 2b 3a d. 1c 2a 3b e. 1b 2a 3c

30. Монгол улсын гадаад бодлогын хоёр дахь чиглэл аль нь вэ? /2 оноо/

- Хөрш орнуудтай найрсгаар, тэнцвэртэй харилцах
- Азийн бүс нутгийн улс төр, эдийн засгийн интеграцид оновчтой оролцох
- Өрнө, дорнын өндөр хөгжилтэй гүрнүүдтэй найрсаг харилцаа хөгжүүлэх
- Хөгжиж буй орнуудтай нийтлэг зорилтын хүрээнд хамтран ажиллах
- НҮБ болон төрөлжсөн байгууллагууд, дэлхийн банкттай хамтран ажиллах

Хоёрдугаар хэсэг:

31. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу? /4 оноо/

1	Асуулгын арга	a	Урьдчилан бэлтгэсэн асуулт, хариулт бүхий хуудсаар мэдээлэл цуглуулах арга
2	Туршилтийн арга	b	Судалгаанд оролцогчийн зан үйл, үйлдэл, үг яриа, хөдөлгөөн зэргийн талаар тэмдэглэл хөтлөх замаар мэдээлэл цуглуулах арга
3	Ажиглалтын арга	c	Зохиомол орчин бүрдүүлэх замаар мэдээлэл цуглуулах арга
4	Дедукцийн арга	d	Ерөнхий дүгнэлт буюу онолын санааг нэгжид буулган дүгнэлтэд хүрэх арга

1- 2- 3- 4-

32. Өгөгдлийг зөв харгалзуулна уу? /4 оноо/

1	Домог	a	Өөрийн нэр томъёо, багаж хэрэгсэл, туршилтын тоноглол зэргийг ашигладаг.Энэ зорилгын дагуу эрдэм судалгааны байгууллагууд ажилладаг.
2	Шашин	b	Хүн төрөлхтний язгуур сэтгэлгээ бөгөөд эртний нийгэмд хамаарна.Ёс жаяг, зан үйл хэвшиж тогтсоноор хорио цээрийн хэм хэмжээ, бэлгэдлийн эх үндэс тавигдсан.
3	Шинжлэх ухаан	c	Энэ байгууллагын хамгийн том хэлбэр нь сүм хийд бөгөөд археологийн судалгаагаар сүсэг бишрэлийн энгийн хэлбэрүүдийг 40 мянган жил оршин тогтносон гэж судлаачид тэмдэглэдэг.
4	Үнэлэмж	d	Нийтлэг ач холбогдолтой нь хүлээн зөвшөөрөгдсөн, энэ утгаараа эрхэмлэх зүйл, хэм хэмжээний шинжтэй болсон утгат чанарууд юм.

1- 2- 3- 4-

33. Өгөгдлийг зөв харгалзуулна уу? /4 оноо/

1	Монгол улсын Үндсэн хууль	a	Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль	b	Эрэгтэй, эмэгтэй хүн бүр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн ба бусад харилцаанд тэгш эрхтэй байх, нийгмийн баялгаас тэнцүү хүртэх боломж, нөхцлийг хангах
3	Эрүүгийн хууль	c	Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна.
4	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	d	Эрүүгийн харилцаа нь хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төр, алдар хүндийг гутаах шинжгүй байна.

1- 2- 3- 4-

34. Өгөгдлийг зөв харгалзуулна уу? /4 оноо/

1	Захиргааны актыг илрэх хэлбэрээр нь	a	Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор захиргааны байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэр
2	Захиргааны шийдвэр буюу акт	b	Аман, бичгийн, үйл хөдлөл- хөдөлгөөний, техникийн гэж ангилдаг бөгөөд түүнийг танин мэдсэнээр эрхээ хамгаалах боломжтой болдог.
3	Захиргааны байгууллага	c	Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирам -жилсан шийдвэр гаргадаг нийтийн эрх зүйн этгээд
4	Захиргаа иргэдийн хоорондын дунд үүсдэг нэг асуудал	d	Иргэн захиргааны эрх зүйн зөрчил гаргах явдал.

1- 2- 3- 4-

35. Өгөгдлийг зөв харгалзуулна уу? /4 оноо/

1	Бүтцийн ажилгүйдэл	a	Улс төрийн нэг нам ялснаар нөгөө намын төрийн албан хаагчид олноор ажлаас халагдсан
---	--------------------	---	---

2	Шилжилтийн ажилгүйдэл	b	Доржийн цалингийн хэмжээ амьдралд хүрэлцэхгүй байгаа тул өөр өндөр цалинтай ажил хайхаар ажлаас гарсан
3	Ажилгүйдлийн эдийн засгийн үр дагавар	c	Хүн амын орлого, амьжиргааны түвшин буурч ядуурал нэмэгдэн, архидалт, гэмт хэрэг өснө. Боловсролын түвшин доройтон өвчлөл нэмэгдэнэ
4	Ажилгүйдлийн нийгмийн үр дагавар	d	Баялаг нэмж үйлдвэрлэх боломжоо алдагдаж боломжит үйлдвэрлэлийн хэмжээ буурна. Хөдөлмөрийн нөөц бүрэн ашиглагдахгүйд хүрнэ.

1- 2- 3- 4-

36. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу? /4 оноо/

1	Цалин	a	Газрын эздийн орлого
2	Зээлийн хүү	b	Мөнгө зээлдүүлэгчдийн орлого
3	Түрээсийн төлбөр	c	Аж ахуйн нэгжийн эздийн орлого
4	Ашиг	d	Ажиллагчдын орлого

1- 2- 3- 4-

37. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу? /4 оноо/

1	Аймаг хуулийн цэц, аймаг, нийслэлийн ИТХ	a	Шийдвэр
2	Монгол Улсын Их Хурал	b	Тогтоол
3	Монгол Улсын Ерөнхийлөгч	c	Зарлиг
4	Монгол Улсын Ерөнхий сайд	d	Тушаал

1- 2- 3- 4-

38. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу? /4 оноо/

1	Иргэдийн улс төрийн оролцоо	a	Ардчилсан нийгэм нь иргэдийг боловсролтой болоход анхаардаг бөгөөд боловсролтой иргэд нь ардчиллыг хөгжүүлэх гол хөшүүрэг
2	Нийтэд тайлагнах, ил тод байх ёс	b	Ардчилсан нийгэм нь иргэдийн эрхийг хамгаалах, албан тушаалтан хаагчдын эрх мэдлээ урвуулан, хэтрүүлэх явдлаас сэргийлэх
3	Эрх мэдлээ хэтрүүлэхэд хяналт тавих	c	Ардчилсан нийгэмд сонгогдсон болон томилогдсон албан тушаалтан ард олонд тайлангаа тавих үүрэгтэй. Тэд өөрсдийн үйл ажиллагааны төлөө хариуцлага хүлээнэ.
4	Боловсрол	d	Сонгуульд саналаа өгөх, нэрээ биелүүлэх, жагсаал цуглаан хийх, төрийн байгууллага, албан тушаалтанд санал хүсэлт гаргах зэрэг олон хэлбэрээр хэрэгжинэ.

1- 2- 3- 4-

39. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу? /4 оноо/

1	Их гүрэн	a	Олон улсын харилцаанд нөлөө багатай ч өөрийн тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэрэгсэлтэй байдаг
2	Дунд улс	b	Өөрийн ойрын хүрээлэлдээ ялангуяа хөрш улсууд, бүс нутагтаа баттай нөлөөлдөг, голчлон тогтвортой эдийн засгийн хөгжилтэй улсууд байдаг
3	Бага улс	c	Өөрийн аюулгүй байдлыг төдийгүй хөрш, холбоотой улсууд, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах хүчин чадалтай байдаг
4	Хөрш орон	d	Хил залгаа оршдог, тэр улсын дотоод гадаад бодлого үйл

			ажиллагаанд оролцдог.
--	--	--	-----------------------

1- 2- 3- 4-

40. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу? /4 оноо/

1	Олон тулгуурт байх	A	Энэ зарчим нь гадаад харилцаа, хамтын ажиллагаандаа нөөц бололцоог аль болох бүрэн дайчлан зохион байгуулах явдал юм.
2	Прагматик байх	B	Нэг талаас Монгол улсын үндэсний эрх ашиг, аюулгүй байдлыг сахин хамгаалах үүднээс аль болох олон улс оронтой хамтран ажиллах, нөгөө талаас гадаад харилцааг аль болох олон хэлбэрээр явуулахад оршино.
3	Тэнцвэртэй байх	C	Энэ зарчим нь үндэсний язгуур ашиг сонирхлыг сахин хамгаалсан, үндэсний хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйлчилнэ.
4	Үндэсний эрх ашигт нийцсэн	D	Стратегийн зорилгыг хэрэгжүүлэхдээ шат дарааллыг эрхэмлэсэн, Монгол улсын хувьд стратегийн ач холбогдол бүхий гүрнүүдийн Монгол дахь эдийн засгийн болон бусад сонирхлыг тэнцвэржүүлэхэд чиглэнэ.

1- 2- 3- 4-

